


Ерөнхийлөгч
Томас С.Монсон



Гэр бүлийн хайр

БОШИГЛОГЧИЙН МААНЬ ЗӨВЛӨГӨӨ

Адислагдсан гэр бүлийн амьдрал

“Бид дэлхийн зүйлсийг ихээр мэдэж, үүнээс суралцахдаа энэ нь үнэхээр түр зуурын бөгөөд заримдаа ертөнц хэтэрхий өнгөцхөн, нүд хуурсан болохыг ухаардаг бөгөөд энэ үед гэр бүл болон бидний хайртай хүмүүсийн үнэнч байдал зэрэг итгэж найдаж болох зүйлс бидэнд байгаад баярлан талархах нь өсөн нэмэгддэг билээ. Үүрэг хариуцлага, хүндэтгэл, нийтэч зан чанар зэргээр хоорондоо холбогдоно гэдэг юу гэсэн утгатай болохыг бид мэддэг. Адислагдсан гэр бүлийн амьдралын хэлхээ холбоог юугаар ч орлуулж болохгүйг бид ухаардаг.”¹

Хайраа бусадтай хуваалцахуй

“Хүүхдүүдээ сайшаан урамшуулж, тэврээд ‘Хайртай шүү миний хүү, охин’ гэж байн байн хэлж, талархлаа үргэлж илэрхийлж бай. Шийдэх ёстой асуудлаа хайрлах ёстой хүнээсээ хэзээ ч бүү дээгүүр тавь. Найз нар маань алс холыг зорин, хүүхдүүд маань өсөж том болон, хайртай хүмүүс маань хорвоогийн жам ёсоор халин оддог. Тэд бидний амьдралаас холдон одоход

бид ‘хэрэв тэгсэнсэн бол’, ‘хэрэв зөвхөн тэгсэн л бол’ гэж харууслын үгстэй хоцрох тэр мөчийг хүртэл бид тэднийг бидэнтэй үргэлж хамт байх мэт санадаг.

“Амьдралдаа аз жаргалыг мэдэрч, энэхүү аялаасаа баяр баяслыг олж, хайраа найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ хуваалцъя. Нэг л мэдэхэд бидний хүн нэг бүрийн хувьд идэр залуу нас нэгэнт ард өнгөрсөн байх болно. Хамгийн чухал зүйлсийг хойш тавихгүй байцгаая.”²

Хайраа харуулах нь

“Ах нар аа, эхнэртээ хайр, хүндэтгэлийн дээдээр хандацгаая. Хань ижил тань та бидний мөнхийн хамтрагчид билээ. Эгч нар аа, нөхрүүдээ хүндэл. Тэд та нараас сайн сайхан үгсийг сонсох хэрэгтэй. Тэдэнд халуун дулаан инээмсэглэл хэрэгтэй. Тэдэнд үнэнч хайраа илэрхийлж бай. . . .

“Эцэг эхчүүд та нар хайр халамжаа үр хүүхэддээ харуул. Та тэдэнд хайртайгаа мэднэ, гэвч хүүхдүүд тань үүнийг мэдэж байгаа эсэхийг олж хар. Үр хүүхэд эцэг эхдээ үнэт эрдэнэсээс илүү эрхэм юм. Үүнийг тэдэнд мэдүүлцгээе. Үр хүүхдүүдийнхээ өдөр бүрийн

хэрэгцээнд санаа тавин, эцэг эхчүүдэд зайлшгүй ирэх шалгуурыг даван туулахдаа тусламж эрэн Тэнгэрлэг Эцэгтээ хандагтун. Хүүхдүүдээ хүмүүжүүлэхэд танд өөрийн мэргэн ухаанаас илүү зүйлс хэрэг болно.³

Хайраа илэрхийлэхүй

“Эцэг эхчүүд та нар хүүхдүүдээ хайраа илэрхийлж бай. Тэд дэлхийн нүгэлт зүйлсийн эсрэг сөрөн зогсохын тулд тэдний төлөө залбир. Тэд итгэл, гэрчлэлээрээ өсөхийн тулд залбир. Тэд сайн сайхан, бусдад үйлчилсэн амьдралын замаар замнаж болохын тулд залбир.

Хүүхдүүд ээ, аав ээждээ хайртайгаа мэдэгд. Та нарын төлөө хийсэн болон хийх бүх зүйлд хэрхэн талархаж явдгаа аав ээждээ мэдэгд.”⁴

Хамгийн чухал зүйл

“Хамгийн чухал зүйл нь ихэнхдээ бидний эргэн тойронд байгаа хүмүүстэй холбоотой байдаг. Бид тэдэнд хэр их хайртай болохыг тэд өөрсдөө мэдэх ёстой гэж бид заримдаа боддог. Гэвч бид тэгж бодож болохгүй харин тэдэнд хайртайгаа мэдүүлэх хэрэгтэй. Виллям Шекспир ийнхүү бичжээ. ‘Бусдыг хайрладаггүй хүмүүс хайраа илэрхийлдэггүй.’ Бид хэлсэн эелдэг үгс эсвэл харуулсан хайрандаа хэзээ ч харамсахгүй, харин эдгээр зүйлсийг хамгийн дотны, хамгийн хайртай хүмүүстээ хэлээгүйдээ, тэдний төлөө хийх ёстой зүйлээ хийгээгүйдээ бид харамсах болно.”⁵

Диваажинг ойртуулахуй

“Бидний гэр бүл болон гэр орон бие биенээ, сайн мэдээг, ойр дотны хүмүүсээ болон Аврагчаа хайрлах хайраар дүүрэн байх болтугай. Ингэснээр диваажин болон дэлхийн зай бага ч гэсэн ойртох болно.

“Гэр орноо гэр бүлийн бүх гишүүд очих гэж үргэлж яардаг эрхэм ариун газар болгоцгооё.”⁶

Гэр бүлүүдийн төлөөх залбирал

“Өнөөдөр дэлхийд гэр бүлийн нэгжүүд дайралтад өртөхийн хэрээр маш олон ариун зүйлсийг доог тохуу болгож байна. Иймээс бид тулгарч буй сорилт бэрхшээлийн өмнө өөрсдийгөө хүчтэй болгож,

үнэн болон зөв шударгын төлөө бат зогсоход туслахыг Тэнгэрлэг Эцэгээсээ гуйх хэрэгтэй. Бидний гэр орон амар амгалан, хайр энэрэл, сүнслэг байдлаар дүүрэн газар байх болтугай.”⁷

ЭШЛЭЛ

1. “A Sanctuary from the World” *Worldwide Leadership Training Meeting*, 2008 оны 2-р сарын 9, 29.
2. “Joy in the Journey” (Brigham Young University Women’s Conference, 2008 оны 5-р сарын 2), <http://ce.byu.edu/cw/womensconference/archive/transcripts.cfm>
3. “Abundantly Blessed” *Лиахона*, 2008 оны 5-р сар, 112.
4. “Until We Meet Again” *Лиахона* 2009 оны 5-р сар, 113.
5. “Finding Joy in the Journey” *Лиахона*, 2008 оны 11-р сар, 86.
6. “A Sanctuary from the World” 30–31.
7. Гила Валлей Аризона Ариун сүмийн онцгойлон адислалтын залбирал, 2010 оны 5-р сарын 23; “The Gila Valley Arizona Temple: ‘Wilt Thou Hallow This House,’” *Church News*, 2010 оны 5-р сарын 29, 5.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

“Эргэцүүлэн бодуулах үйл ажиллагаанд багш нар асуултууд асууж, нөхцөл байдлыг илэрхийлэн, суралцагчдын асуултуудад хариулж, санаа бодлоо хуваалцах багахан хэмжээний цаг өгөх хэрэгтэй” (*Teaching, No Greater Call* [1999], 160). Дээрх зүйлсийг гэр бүлийнхэнтэйгээ хамт уншихдаа тэдэнд нөлөөлсөн зөвлөмж болон санаануудыг олж сонсохыг хүс. Гэр бүлийн гишүүд гэртээ хайр энэрлийг өсгөн нэмэгдүүлэх арга замуудын тухай ярилцаж болно. Дараагийн гэр бүлийн үдшээр эдгээр санаануудыг дахин давтан бататгахад гэр бүлийнхнээ урьж болно.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Ээж биднийг аварсан

Патриша Ауксиер

Би есөн настай байхдаа дүүтэйгээ хамт эгчийнхээ тоглосон сагсан бөмбөгийн тэмцээнийг үзэж байлаа. Аав маань тэмцээнээс түрүүлээд гараад явахад бид түүнтэй харихаар араас нь гарлаа. Бид аавыгаа олж чадаагүй учраас ээжтэйгээ хамт явахаар биеийн тамирын заал уруу явсан боловч биднийг тэнд очиход ганц ч хүн байсангүй.

Дүү бид хоёр борооноос нуугдаж хаалганы дэргэд зогсоод хэн нэгэн биднийг олоосой хэмээн залбирч байв. Хаалга чахран дуугарахад бид дуу гарч байгаа зүг уруу яаран гүйж очсоноо санадаг. Яг тэр үед хүүхэд насны маань хамгийн гэгээлэг дурсамжуудын нэг нь

тохиолдсон юм: “тахиа дэгдээхийнүүдээ далавчин до-роо цуглуулдаг шиг” (3 Нифай 10:4) ээж минь биднийг энгэртээ тэвэрсэн юм. Ээж минь биднийг аварсан бөгөөд би урьд өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй ихээр аюулгүй байдлыг мэдэрсэн.

Надад үзүүлсэн ээжийнхээ нөлөөг бодохоор намайг Аврагч уруу чиглүүлж, “доош унжсан гарнуудыг өргөж, сул дорой өвдөгнүүдийг хүчирхэг болгох” гэдэг нь юу гэсэн утгатай болохыг ээжийн минь амьдрал надад харуулсныг би ойлгодог (С ба Г 81:5). Тэрээр “өөрт нь байгаагаас илүү” хүч чадлыг [түүнд] өгдөг Есүс Христэд итгэл найдвараа тавьсан билээ (“Lord, I Would Follow Thee,” *Hymns*, no. 220).

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Аз жаргалтай гэр бүлийг бий болгох нь

Ерөнхийлөгч Монсон аз жаргалтай гэр бүлийг бий болгох арга замуудыг бидэнд зөвлөсөн билээ. Аз жаргалтай гэр бүлийг бий болгохын тулд гэр бүлийнхээ хамт өөрийн хийж болох зүйлсийг энэ өгүүллээс олж уншаарай.

Хэрэгжүүлж болох ямар нэгэн санаа төрсөн үед түүнийгээ бичиж тэмдэглэ. Аз жаргалтай гэр бүлийг бий болгох доод тал нь таван арга замыг бодож олоод, нэг байшин дотор гэр бүлээ зур.



Ариун эмэгтэйчүүдийн нийгэмлэг

Энэ материалыг судалж, гэрээр нь очиж заадаг эгч нартай аль болох тохиромжтой арга замаар ярилиц. Эгч нарыг хүчирхэгжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд чинь идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Нийгмийн Халамжийн Бүлгийн 2 дахь ерөнхий ерөнхийлөгч Элиза Р.Снөү сургасан нь: “Эрт үед Төлөөлөгч Паул ариун эмэгтэйчүүдийн тухай өгүүлсэн байдаг. Ариун эмэгтэй байх нь бид бүхний үүрэг мөн. Хэрэв бид ариун эмэгтэйчүүд юм бол өндөр зорилготой байх ёстой. Чухал үүрэг гүйцэтгэхээр дуудагдсанаа мэддэг, мэдэрдэг байх ёстой. Хэн ч эдгээр үүргээсээ чөлөөлөгдөхгүй. Бусдаас тусгаарлагдчихсан, хэлхээ холбоо, нөлөө нь хумигдчихсан эгч нэг ч байхгүй. Харин тэрбээр дэлхий дээр Бурханы Хаант улсыг байгуулахад их зүйл хийж чадна.”¹

Эгч нар бид нийгмээс тусгаарлагдсан ямар ч нөлөөгүй болсон хүмүүс биш шүү дээ. Бид Нийгмийн Халамжийн Бүлэг дэх үйл ажиллагаанаас ирдэг бэлгийг хүлээн авснаараа Бошиглогч Иосеф Смитийн дүрсэлсэн “дэлхийн бүх хилэнцээс ангид, шилдэг, ариун журамтай, цэвэр ариун” хамтын нийгэмлэгийн хэсэг болдог билээ.²

Энэхүү хамтын нийгэмлэг нь удирдах, үйлчлэх мөн заах боломжуудыг олгодгоороо бидэнд итгэлээ бэхжүүлж, сүнслэг байдлаа өсгөн нэмэгдүүлэхэд маань тусалдаг. Бид үйлчилснээрээ амьдралдаа шинэ хэмжүүрийг

нэмж бий болгон, сүнслэг байдлын хувьд өсч хөгжин, хамт олны хэсэг гэдгээ мэдэрч, өөрийгөө эрхэмлэн үнэлж, хүч боломжоо танин мэдэх нь дээшилдэг. Сайн мэдээний төлөвлөгөөний нийтлэг зорилго бол чадавхийнхаа оргилд хүрч, өсч хөгжих боломжоор өөрсдийгөө хангах явдал гэдгийг бид мэднэ.

Нийгмийн Халамжийн бүлэг бидэнд ариун сүмийн адислалуудыг хүлээн авахаар бэлтгэх, гэрээнүүддээ хүндэтгэлтэй хандах болон Сионы үйл хэрэгт идэвхтэй байхад тусалдаг юм. Нийгмийн Халамжийн Бүлэг бидэнд итгэл, хувийн зөв шударга байдлаа нэмэгдүүлж, гэр бүлээ бэхжүүлэн, тусламж хэрэгтэй хүмүүсийг эрж олон тэдэнд туслахад дэмжлэг үзүүлдэг.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ажил ариун бөгөөд ариун ажлыг хийх нь бидний дотоод сэтгэлд цэвэр ариун чанарыг бий болгодог.

Сильвия Х.Оолред, Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх.

Судруудаас

Египетээс Гарсан нь 19:5;
Дуулал 24:3–4; 1 Тесалоник 4:7;
Тит 2:3–4; Сургаал ба Гэрээ 38:24;
46:33; 82:14; 87:8; Мосе 7:18

Бидний түүхээс

Бошиглогч Иосеф Наувугийн Эмэгтэйчүүдийн Нийгмийн Халамжийн бүлэгт хандаж үг хэлэхдээ цэвэр ариун байдлыг онцлон тэмдэглэж, эгч нар цэвэр ариун байх юм бол дэлхийд онцгой нөлөө үзүүлэх болно гэжээ. Тэрбээр хэлсэн нь: “Номхон дөлгөөн байдал, хайр энэрэл, цэвэр ариун байдал та нарыг гоён чимдэг байх ёстой. . . . Энэ Нийгэмлэг . . . хатад хаадад зарлиг болгох хүчтэй байх болно. . . . Дэлхийн хаад хатад Сионд ирж, хүндэтгэл үзүүлэх болно.” Гэрээнүүдийнхээ дагуу амьдардаг Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар зөвхөн сайн санаат хүмүүсийн хүндэтгэлийг хүлээгээд зогсохгүй “хэрэв та нар онцгой боломжийнхоо дээд хэмжээгээр амьдрах юм бол тэнгэр элчүүд та нарын түншүүд байхаас татгалзахгүй” хэмээн Иосеф эгч нарт амласан юм.³

Эгч нар бусдад үйлчилж, тэднийг аврах ажилд оролцсоноороо өөрсдийгөө ариусгадаг. Бошиглогчийн ээж Люси Мак Смит, ажлаа сайн явуулдаг Нийгмийн Халамжийн бүлгийн тухай: “Бид бүгдээрээ тэнгэрт хамтдаа зэрэгцэн суухын төлөө бие биеэ дэмжиж, анхаарч халамжлан, тайтгаруулж, заавар зөвлөгөө өгдөг байх ёстой” хэмээн хуваалцжээ.⁴

ЭШЛЭЛ

1. Элиза Р.Снөү, "An Address," *Woman's Exponent*, 1873 оны 9-р сарын 15, 62.
2. Иосеф Смит, *History of the Church*, 4:570.
3. Иосеф Смит, *History of the Church*, 4:605, 606.
4. Люси Мак Смит, Relief Society, Minute Book, 1842 оны 3-р сар. 1844 оны 3-р сар, 1842 оны 3-р сарын 24-ний өдрийн тэмдэглэл, Сүмийн түүхийн номын сан, 18-19.

Би юу хийж чадах вэ?

1. Би бүлгийнхээ эгч нарыг "өндөр зорилго" тавьж, зорилгодоо хүрэхэд нь тэдэнд хэрхэн туслах вэ?"

2. Би амьдралаа "сонгомол, ариун журамтай, цэвэр ариун" болгохын тулд юу хийх вэ?

Нэмэлт мэдээллийг
www.reliefsociety.lds.org-аас
үзнэ үү.